

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1064
танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Монголын либерал нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Монголын либерал нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Монголын либерал нам"-ын мөрийн хөтөлбөр /¹²..... хуудас/-ийг хавсаргав.


МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030666

Монголын Либерал Намын даргын
2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн
05/24 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт



“ХҮЧИРХЭГ МОНГОЛ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР




A handwritten signature in black ink, appearing to be "Lamas" followed by a horizontal line.

Оршил

Монгол Улсын Тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт Ардчилсан нийгмийг хамгаалан бэхжүүлж, үндэсний үзлийг сэргээн түгээж, хувь хүний эрх, эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт эдийн засаг, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх либерал намын хувьд

Монгол хүн бүрийг эрх тэгш, эрх чөлөөтэй, хүсэл мөрөөдөлтэй, аз жаргалтай амьдрах боломжийг бүрдүүлэн хариуцлагатай, шударга, авилгаас ангид ухаалаг төрийг бий болгож Ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгож

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөөг дээдэлсэн Бүрэн Ардчиллыг цогцлоохоор
- Монгол хүн бүрийн тогтвортой орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хараат бус бие даасан байдлыг бүрдүүлэх, хувийн өмч, чөлөөт өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал бэхжүүлэхээр
- Үндэсний өв уламжлал түүх соёлоо дээдлэн Тусгаар тогтнол Бүтэн Монгол улсаа хадгалан, хамгаалахыг үнэт зүйлээ болгон тунхагласан “ХҮЧИРХЭГ МОНГОЛ” мөрийн хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.



Amus 2

00000002

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ

1. ЭРХ ЧӨЛӨӨТ, ОРЛОГОТой ИРГЭН

- 1.1.1. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдох татварын асуудлаар цогц бодлогыг боловсруулж, аливаа санал, санаачилгыг дэмжин ажиллана.
- 1.1.2. Хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан барих бодлого баримтална.
- 1.1.3. Бичил бизнес, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэлийг дэмжсэн бага хүүтэй, барьцаа хөрөнгө шаардахгүй зээлийн бодлого хэрэгжүүлэн гарааны бизнес эрхлэгчдийг дэмжинэ.
- 1.1.4. Цалин, тэтгэврийн буюу баталгаат зээлийн нөхцлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтолцоог сайжруулж эрх зүйн шинэчлэлийг бий болгоно.
- 1.1.5. Шинээр бизнес эрхлэгч иргэдийн үйл ажиллагааг тогтворжуулахад шаардлагатай зөвлөгөө, сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.1.6. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх олон эх үүсвэрийг бий болгож ажил эрхлээгүй хөдөлмөрийн насанд хүрсэн гишүүдийг мэргэшил, мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.1.7. Банк, санхүүгийн салбарт эрх зүйн шинэчлэл хийж зөв мөнгөний бодлогыг баримталснаар иргэдэд тулгарч буй өндөр хүүтэй богино хугацаатай зээлийн тогтолцоог халж иргэдийг санхүүгийн эрсдэл, өрийн дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлнэ.
- 1.1.8. Иргэний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх суурь эрхийг баталгаажуулж шаардлагатай эрх зүйн өөрчлөлтийг хийнэ.
- 1.1.9. Иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хууль ёсны эрхээ хамгаалуулж чадах шударга шүүхийн тогтолцоог дэмжин, эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхийн төлөө ажиллана.

1.2. ЭРҮҮЛ ИРГЭН

- 1.2.1. Эрүүл мэндийн салбарын төсөв санхүүжилт, зарцуулалтын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгон авлига, ашиг сонирхлын зөрчлийг устгана.
- 1.2.2. “Эрүүл иргэн” хөтөлбөр хэрэгжүүлэн эрүүл мэндийн салбарын тогтолцоонд өөрчлөлт шинэчлэлтийг хийнэ. Үндэсний хэмжээний үзлэг оношилгооны төрөлжсөн, цогц төвийг байгуулж олон улсын эрүүл мэндийн байгууллага, эмнэлэг, эмч нартай хамтран анагаах ухааны сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх чиглэлээр ажиллана.
- 1.2.3. Хавдар, зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт оношлох, халдварт болон халдварт бус өвчний эрсдэлийг бууруулах асуудлаар дорвитой арга хэмжээ авч эрүүл амьдралын хэв маягийг түгээн дэлгэрүүлэх аливаа үйл ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулна.

- 1.2.4. Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэд даатгалаараа чийрэгжүүлэх төвүүдэд хичээллэх боломжийг бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгохын төлөө ажиллана.
- 1.2.5. Өндөр үнэтэй иргэдэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эмийн үнийн хөөргөдлийг хязгаарлан иргэнд учрах санхүүгийн дарамт хүндрэлийг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.
- 1.2.6. Яаралтай тусламжийн чадавхыг дээшлүүлж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, гамшиг осол гарсан зайлшгүй шаардлагатай үед агаарын тээврийн ашиглалтыг сайжруулна.
- 1.2.7. Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай байгаа боловсон хүчний судалгааг хийж хүний нөөцийн бүрдүүлэлтэд онцгой анхаарч сувилагч, асрагчаар суралцагсдыг тоог нэмэгдүүлж, нийгмийн асуудал, ажиллах орчныг сайжруулан ажиллана.
- 1.2.8. Иргэдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тэгш хамрагдах нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой арга хэмжээ авч, үйл ажиллагаа хэрэгжүүлнэ
- 1.2.9. Иргэдэд анхан шатны эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээ үзүүлж буй өрхийн эмнэлгийн санхүүжилт, зохион байгуулалтыг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.

1.3. АХМАДЫН ХӨГЖИЛ, ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

- 1.3.1. Тэтгэврийн хэмжээг инфляци, үнийн өсөлттэй уялдуулан барих цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 1.3.2. Ахмад настны хөгжих, суралцах чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх ахмадын өргөө, хөгжлийн төвүүдийг байгуулна.
- 1.3.3. Ахмад настны мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөл боломжийг бүрдүүлэх, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр хэрэгжүүлэх асуудлаар дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.4. Ахмад настны эрүүл мэндийн үзлэг оношилгоо, эмчилгээгээр дагнасан сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг хөгжүүлэх, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулах бодлого, санаачилгыг дэмжинэ.

1.4. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД

- 1.4.1. Тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж бодлого боловсруулна.
- 1.4.2. Тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн болон хувийн хэвшлээс үйлчилгээ авах нөхцөл, шаардлага стандартад тохирсон орчин бүрдүүлэхээр ажиллана.
- 1.4.3. Тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асран хамгаалж хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа иргэний нийгмийн хамгааллын асуудлаар бодлого хэрэгжүүлнэ.

1.4.4. Зайлшгүй тусламж үйлчилгээ шаардлагатай тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамж үйлчилгээний төв байгуулна.

1.5. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ТЭГШ ОРОЛЦОО

1.5.1. Гэр бүл төлөвлөлт, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх талаар соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

1.5.2. Гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.

1.5.3. Залуу гэр бүлийн орлогод нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууц худалдан авах нөхцлийг бүрдүүлэх асуудлаар бүхий л арга хэмжээг авч ажиллана.

1.5.4. Орлого багатай өрх, гэр бүлийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх халамжийн оновчтой тогтолцоог нэвтрүүлнэ.

1.5.5. Хүүхдийн эрх, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхдэд ээлтэй нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ.

1.5.6. Болзошгүй зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих сургууль цэцэрлэгийн орчим гарц гэрлэн дохио, хурд сааруулагч, камертай болгоно.

1.5.7. Хүүхдийн тоглоомын талбайд орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

1.5.8. Гэр бүлийн болон бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нөхөн сэргээх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх төвийг нийслэл, орон нутагт байгуулна.

1.5.9. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял шийтгэлийг чангатгах хууль эрх зүйн орчин бүрдүүлж ажиллана.

1.5.10. Хүүхэд асрах чөлөөтэй ээжүүдийн ажлын байрыг хадгалах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх эрх зүйн тогтолцоог бий болгоно.

1.5.11. Нийгэм дэх эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг бодитоор дэмжих, шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.6. БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

1.6.1. Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлж үе шаттайгаар арга хэмжээ авч ажиллана.

1.6.2. Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөдөлмөрийн хөлсийг инфляцын түвшин, ажлын ачаалал зэрэгтэй уялдуулан нэмэгдүүлэх урамшууллын тогтолцоо бий болгоно.


1.6.3. Бүх шатны сургалтын байгууллагын багш нарын хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтад хамруулан чадварлаг мэргэшсэн багш бэлтгэх тасралтгүй үйл ажиллагааг зохион байгуулна.

5


00000005

- 1.6.4. Гадаадад төрийн зардлаар боловсрол эзэмших иргэдийн сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, шударга болгож, суралцагсдын тоог нэмэгдүүлэхийг зорьж ажиллана.
- 1.6.5. Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, удирдах албан тушаалтны хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийхдээ мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь тулгуурлан сонгон шалгаруулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.6.6. Өвлийн улиралд хүүхдийг ханиад, томуу, халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор ЕБС-ийн сурагчдын өвлийн амралтын хугацааг уртасгах зохицуулалт хийнэ.
- 1.6.7. Тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.6.8. Улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийг 1 ээлжээр хичээлдэг болгоно.
- 1.6.9. Ковид -19 цар тахлаас үүдсэн ерөнхий боловсролын сургуулийн танхимын хичээл завсардалт, теле-хичээлийг дэмжиж боловсролын агуулгыг онлайн, зайн сургалтын агуулгыг баяжуулан хичээл хоцрогдлыг нөхөх шинэ системийг нэвтрүүлж ажиллана.
- 1.6.10. Нүхэн жорлонтой бүх шатны боловсролын байгууллага, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгох зорилт тавьж ажиллана.
- 1.6.11. Боловсролын зээлийн сангийн зарцуулалтад хяналт тавьж, сонгон шударга явуулан, хүртээмжийг нэмэгдүүлж, оюутнуудыг санхүүгийн дарамтгүйгээр суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.6.12. Оюутны сургалтын төлбөрийн зээлийн нөхцлийг сайжруулах, өргөн хүрээнд хамрагдах боломжийг эрэлхийлэн ажиллана.
- 1.6.13. Монгол улсад нэн шаардлагатай 50 мэргэжлийг тодорхойлж тус мэргэжлээр оюутан суралцах нөхцлийг дэмжинэ.
- 1.6.14. Дээд боловсрол гэдэг ойлголтыг өргөжүүлж, зарим мэргэжлийн хөтөлбөрийг хамруулах хэрэгтэй. Цахилгаанчин, сантехникч, механикч, барилгачин, бүх төрлийн техникч зэрэг нь улс орны хөгжил, бүтээн байгуулалтанд бусад мэргэжилтэй адил чухал үүрэгтэй.
- 1.6.15. Бүсийн хөгжлийг дэмжиж, орон нутгийн онцлогт уялдуулсан хөдөө аж ахуй, уул уурхай, хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэрийн чиглэлээр салбар сургуулиудыг байгуулах ажлыг зохион байгуулж төвлөрлийг сааруулахад анхаарч ажиллана.
- 1.6.16. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чадавхыг дээшлүүлэх үүднээс эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг жил бүр тогтмол нэмэгдүүлэх замаар мэдлэгт суурилсан хөгжлийг бий болгоно.
- 1.6.17. Оюутан бүрийн чадвар, бүтээлч байдлыг зөв харуулж чадах олон төрлийн сургалтын хөтөлбөрөөр хангана.

ХОЁР. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХАЛАМЖИЙН ТОГТОЛЦОО

 6

00000000


2.1. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

- 2.1.1. Нийгмийн даатгалын сангийн бие даасан, хараат бус байдлыг хангаж, тайлан мэдээллийг олон нийтээр хянах тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.1.2. Малчдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулж нийгмийн баталгаа бүрдүүлэх хууль эрх зүйн шинэчлэлт хийнэ.
- 2.1.3. Нийгмийн халамж үйлчилгээний салбарт сайн дурын ажлыг дэмжих, урамшуулах хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.1.4. Хүн амын зорилтот бүлгүүдэд нийгмийн халамжийн үйлчилгээг үр өгөөжтэй, оновчтой хүргэх бодлогыг хэрэгжүүлнэ. Хавтгайрсан халамжийн бодлогоос эрс татгалзан шинэчлэлт хийнэ.
- 2.1.5. Монгол хүний дундаж наслалт, бие физиологи, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлтийн онцлог зэргийг харгалзан үзэж тэтгэвэр тогтоолгох тогтолцоог бүрдүүлэхэд анхаарна.
- 2.1.6. Тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхахгүй байх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд тэгш хамруулах, дэд бүтцийг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тогтмол орлоготой болгох аливаа бодлого, үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 2.1.7. Монгол Улсын иргэн бүрийг эрүүл аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, засаг захиргааны нэгж тус бүрээр шинэчлэл хийх зорилт тавьж ажиллана.
- 2.1.8. Хүүхдийн эрхийг хамгаалах, эрүүл аюулгүй өсөх нөхцөлийг бүрдүүлэх бүхий л арга хэмжээг авч бодлогын түвшинд баримт бичиг боловсруулан хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХҮЧИРХЭГ ЭДИЙН ЗАСАГ

3.1. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- 3.1.1. Олон тулгуурт эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж уул уурхай, ашигт малтмалаас гадна хөдөө аж ахуй, аялал жуулчлал, технологи, үйлдвэрлэлийн салбарыг дэмжиж эдийн засгийн өсөлтийг төрөлжүүлэх бодлогын оновчтой тогтолцоог нэвтрүүлнэ.
- 3.1.2. Эдийн засгийг үсрэнгүй өсөлтөд хүргэх томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт үйл ажиллагааг эрчимжүүлэн ган, зэс, нүүрс, нефт, хар төмөрлөгийн аж үйлдвэрийг бүс нутгийн онцлог, хүн амын суурьшил, байгалийн онцлог, нөөцөд тулгуурлан хөгжүүлнэ.
- 3.1.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, илэрсэн орд газрыг улсын нөөцийн санд бүртгэж, нөөц нь тогтоогдсон газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар үндэсний хэмжээний баялгийн сан байгуулах, баялагийн сангийн үйл ажиллагааг зөв зохион байгуулах шийдлийг тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- 3.1.4. Үндэсний эрх ашиг, бизнесийн шударга ёсыг эрхэмлэсэн харилцан ашигтай гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтална. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад орнуудаас ирэх зээл, тусламжийн зарцуулалтад

7


00000007

хяналт тавьж, үр ашгийг нэмэгдүүлэх замаар төсвийн сахилга батыг чангатган хууль эрх зүйн орчныг сайжруулна.

- 3.1.5. Банк, санхүүгийн салбарын урт хугацаанд тогтвортой байдлыг хангасан зээлийн хүүгийн зохистой, үр ашигтай бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.1.6. Хүнсний үйлдвэрлэлийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангахаар зорино.
- 3.1.7. Улсын валютын нөөцийг нэмэгдүүлж, инфляцын түвшинг багасгах төгрөгийн ханшийн уналтыг зогсоох мөнгөний тогтвортой бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.1.8. Хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн салбарыг дэмжих, хөнгөлөлт үзүүлэх бодлогыг баримтална.
- 3.1.9. Хөдөлмөрийн хөлсийг шат дараалалтай нэмэгдүүлж дундаж давхаргын иргэдийн амьжиргааг бодлогын түвшинд дэмжих, хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.1.10. Бизнес эрхлэгчдэд аливаа дарамт учруулахгүйгээр төрөөс үзүүлэх үйлчилгээг хөнгөвчлөх, хууль эрх зүйн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 3.1.11. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогоор баталсан дотоодын төмөр замын нэгдсэн сүлжээг өргөжүүлж, гуравдагч хөрштэй хийх арилжааны гарцыг бий болгох чиглэлээр идэвхийлэн ажиллана.
- 3.1.12. Эрчим хүчний хараат бус байдлыг хангах, эрчим хүчний экспортын нөхцлийг бүрдүүлнэ.
- 3.1.13. Томоохон төслүүдийг хэрэгжүүлэх замаар жижиг бизнесийг дэмжих, оролцох нөхцөлийг бүрдүүлэх.
- 3.1.14. Улсын төсвийг дэд бүтэц, эрүүл мэнд, боловсрол, хүүхэд асрах болон дотоодын суурь хөгжлийг дэмжих төслийг санхүүжүүлэхэд зарцуулна.
- 3.1.15. Үр ашиггүй, бодит бус зохицуулалт нь ирээдүйн өсөлтийн хөдөлгүүр, эдийн засгийн хөгжилд саад учруулахаас урьдчилан сэргийлэхийн тулд бид хуучирсан, шаардлагагүй хууль эрх зүйн тогтолцоог идэвхтэй халж, хувийн хэвшлийнхний хүсэлтийг засгийн газарт шуурхай хүргэж, хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай зохион байгуулна. Компаниуд өөрсдөө дагаж мөрдөх тогтолцоо гэх мэт зохицуулалтуудыг санал болгож, бодлогын чиглэлийг өмнө нь хориглодог байснаас хэрэглэгч төвтэй "тэргүүлэх зөвшөөрөл ба дараах зохицуулалт" болгон өөрчилдөг.
- 3.1.16. Эх орныхоо оюуны өмчийн эрхийг дотоод, гадаадад хамгаалах арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлэн зах зээлд чанартай ажлын байр бий болгож чадах, өрсөлдөх чадвартай шинэлэг стартапуудыг бий болгохын тулд санхүү, татвар, институцийн сайжруулалт, хүний нөөц, технологи зэрэг олон салбарт дэвшилтэт, шинэлэг дэмжлэгийг нэвтрүүлэх болно.

3.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 3.2.1. Аялал жуулчлалын хөтөлбөр, үйлчилгээг олон улсын түвшинд хүргэж соёл урлагийн арга хэмжээг нэмэгдүүлэн дэлхийн аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлж, жуулчдын тоог жил бүр тогтмол өсгөж орлогын тогтвортой эх үүсвэр болгоно.

- 3.2.2. Аялал жуулчлалын салбарт дэд бүтэц, үйлчилгээний чанар стандартыг сайжруулан жилийн дөрвөн улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулах хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 3.2.3. Гадаад аялал жуулчлалын салбарт сурталчилгаа, маркетингийн үр өгөөжтэй ажлуудыг санаачлан шат дараатай хэрэгжүүлж нэг цонхны гадаад бодлого баримталж ажиллана.
- 3.2.4. Аялал жуулчлалын салбарын статистик бүртгэл, мэдээллийг чанаржуулан тогтмол гаргаж, судалгаанд тулгуурласан хөгжлийн бодлого боловсруулан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг оновчтой төлөвлөнө.
- 3.2.5. Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 3.2.6. Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу байршилд түр буудаллах, үйлчилгээний цогцолборууд байгуулна.
- 3.2.7. Аялал жуулчлалын мэргэжлийн төв байгуулж, боловсрол, сургалт, судалгаатай хөгжүүлнэ.

3.3. МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН

- 3.3.1. Махны экспортын бодлогод нийцүүлэн мал бордох технологийг нэвтрүүлж махны экспортын хэмжээ, экспортлогч орны тоог нэмэгдүүлнэ.
- 3.3.2. Малын гаралтай арьс, шир, үс, ноос, ноолуурыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 3.3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжих талаар цогц бодлого хэрэгжүүлж ажиллана.
- 3.3.4. Дотоодын төмс, байцаа, манжин, лууван, сонгино, саримсны дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, гадаад зах зээлд экспортлох зорилт тавьж ажиллана.
- 3.3.5. Өвлийн хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны дотоодын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.
- 3.3.6. Төмс, хүнсний ногооны импортын гаалийн татварыг нэмэгдүүлж, дотоодын зах зээлийг хамгаална.
- 3.3.7. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээл, тоног төхөөрөмж, технологийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлэн болзошгүй эрсдэл, ган зудаас урьдчилан сэргийлнэ.
- 3.3.8. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийг өсгөх, дотооддоо боловсруулж экспортын бүтээгдэхүүн болгох бүхий л санал, санаачилгыг дэмжин нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн боловсруулахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.4. ОРОН СУУЦЖУУЛАЛТ

- 3.4.1. Орон сууцны үнийг тогтвортой болгох, ипотекийн нөхцлийг сайжруулах замаар иргэдийг орон сууцжуулах бодлого, санаачилгыг дэмжиж ажиллана.

- 3.4.2. Барилгын салбарын аж ахуй нэгж, хөрөнгө оруулагчдыг дэмжих замаар бүтээн байгуулалтыг эрчимжүүлж түрээсийн орон сууц болон **түрээслээд өмчлөх** хэлбэрийн орон сууцны тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.4.3. **“200 мянган айл”** орон сууцжуулах үндэсний хөтөлбөрийг тусгай нөхцөлөөр, бүсчилсэн төлөвлөлтийн дагуу урт хугацаанд хэрэгжүүлэх,

ДӨРӨВ. УЛААНБААТАР ХОТ, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

4.1. ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ, АЮУЛГҮЙ АМАР ТАЙВАН ХОТ

- 4.1.1. Явган олон унадаг дугуй, цахилгаан бага оврын тээврийн хэрэгслээр зорчих боломж бүрдүүлэхэд анхаарч, төлөвлөлт, бүтээн байгуулалтыг хийнэ. Явган замын чанар, хүртээмжид анхаарч бүх чиглэлд дугуйн зам бий болгож унадаг дугуйн хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 4.1.2. Иргэдийн амарч тухлах, чөлөөт цагаа өнгөрөөх, орчин үеийн шийдэл бүхий амралтын бүс, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнг хэрэгцээт байршлуудад байгуулж, арчлалт хамгаалалтыг тогтмолжуулна.
- 4.1.3. Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд зөвшөөрөлгүй баригдсан барилга байгууламж, хайс хашлагыг чөлөөлж сургууль, цэцэрлэг авто машины зогсоолын тоог нэмэгдүүлнэ.
- 4.1.4. Иргэдээ эрүүл, аюулгүй орчинд амьдруулах, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын камерын тоог нэмэгдүүлэн хяналтын нэгдсэн төвийг байгуулна.
- 4.1.5. Хог хаягдлын менежментэд онцгой анхаарч дахин боловсруулалт, ангилан ялгалт, тээвэрлэлтийн цогц бодлого боловсруулан тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагыг тогтмол дэмжих бодлого боловсруулан ажиллана.
- 4.1.6. Улаанбаатар хотын гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн нэгдсэн стандартыг бий болгож, хотын соёлыг төлөвшүүлнэ.
- 4.1.7. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд газраа орон сууцаар солих хөтөлбөрийг үргэлжлүүлж, газраа барьцаалан амины орон сууц барих иргэдийг ипотек болон бусад төрлийн хөнгөлөлттэй зээлд хамруулах боломжийг нэмэгдүүлнэ.

4.2. НИЙТИЙН ТЭЭВЭР, ДЭД БҮТЭЦ ХӨГЖСӨН ТҮГЖРЭЛГҮЙ ХОТ

- 4.2.1. Их багтаамжийн нийтийн тээвэр, метро байгуулах, бүтээн байгуулалтыг дэмжсэн бодлого, үйл ажиллагаа явуулж хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтална.
- 4.2.2. Улаанбаатар хотыг гадна тойруугийн замыг байгуулж, хотоор дамжин өнгөрөх ачаа тээвэр, бусад тээвэр логистикийн эрчмийг сайжруулна.
- 4.2.3. Улаанбаатар хотын авто замын уулзвар, гэрлэн дохионы байршлуудад судалгаа тооцоолол хийж авто замын хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх үр

ашигтай системийг боловсруулан иргэд, олон нийтэд танилцуулан санал авсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

4.3. ЭРЧИМ ХҮЧ, УС, ДУЛААНЫ ЭХ ҮҮСВЭР

- 4.3.1. Дулаан, цахилгаан, ус хангамж, ариутгах татуургын дэвшилтэт технологи бүхий шинэ шийдлүүдийг гэр хороололд нэвтрүүлэх хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 4.3.2. Сэргээгдэх эрчим хүчээр Улаанбаатар хотын цахилгаан, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлого төлөвлөлтийг хийнэ.
- 4.3.3. Дулааны цахилгаан 2, 3, 4 дүгээр станцуудын өргөтгөл, засвар бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж шуурхай арга хэмжээ авч ажиллана.
- 4.3.4. Улаанбаатар хотын унд, ахуйн усны хэрэглээ, ашиглалт зарцуулалтыг хэмнэхэд онцгой анхаарна. Үйлдвэрлэл, үйлчилгээ, хот нийтийн аж ахуйн салбарт саарал усыг хэрэглэх хэрэглээг нэмэгдүүлэх журам баталж мөрдүүлнэ.
- 4.3.5. Төв цэвэрлэх байгууламжийг, засварлах асуудалд хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын талаас дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.3.6. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулах, ашиглах усан сан байгуулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.4. ГАМШГИЙН ҮЕИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

- 4.4.1. Туул, Сэлбэ, Улиастай голын хамгаалалтын зурвасыг шинэчлэн тогтоож үерийн эрсдэлтэй бүст суурьшсан иргэд, аж ахуй нэгж байгууллагын тоог бууруулж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж шаардлагатай бүсэд газар чөлөөлөлтийн ажлыг зохион байгуулна.
- 4.4.2. Улаанбаатар хотын үерийн далан болон ус зайлуулах суваг шинээр барих санал санаачлагыг дэмжин, үер, усны гамшиг эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гаргаж ажиллана.
- 4.4.3. Газар хөдлөлт, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс барилга, байгууламж, орон сууцыг бүртгэлжүүлэх, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг шинэчлэх, дахин төлөвлөх, хүчитгэх ажлыг зохион байгуулна.

4.5. ИРГЭНИЙ ОРОЛЦООТОЙ ЗАСАГЛАЛТАЙ ХОТ

- 4.5.1. Улаанбаатар хотын эдийн засаг, хүн ам зүйн харьцаа төвлөрлийг тооцоолон засаг захиргаа, нутаг дэвсгэрийг нэгжийг шинэчлэн зохион байгуулна.
- 4.5.2. Иргэд, нийтийн оролцоотой хөгжлийг чухалчлан нийтийн эрх ашиг, аж амьдрал нөлөөлөхүйц шийдвэр гаргах, хууль, журмыг хэлэлцэн батлахын өмнө иргэдэд сурталчлах, санал авах ухаалаг тогтолцоог бий болгоно.
- 4.5.3. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нээлттэй хэлбэрээр зохион байгуулж

хөндлөнгийн хяналтыг иргэд, олон нийтийн байгууллагаар хийлгэх, төсөвт хэмнэлттэй, эдийн засгийн үр өгөөжтэй байх зарчмыг баримтална.

4.6. АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛГҮЙ ХОТ


- 4.6.1. Сайжруулсан шахмал түлш, хагас коксжуулсан түлшний үйлдвэрлэлийг багасгаж гэр байшин, орон сууцны дулаалгыг сайжруулан агаар, орчны бохирдлыг бууруулна.
- 4.6.2. Гэр хорооллын айл өрхүүдийн дунд бохирын нэгдсэн инженерийн байгууламж байгуулах, био болон эко бохирын систем нэвтрүүлж хөрсний бохирдлыг багасгана.
- 4.6.3. Орчин үеийн дэвшилтэд технологийг ашигласан, цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг бодлогоор дэмжиж цэнэглэх цэгүүдийн тоог хүрэлцээтэй хэмжээнд хүртэл нэмэгдүүлнэ.
- 4.6.4. Нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан хөдөлгүүртэй автобусны тоог нэмэгдүүлж, парк шинэчлэлт хийнэ.
- 4.6.5. Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах менежментийг сайжруулна.

4.7. ДАГУУЛ, ХАЯА ХОТУУД

- 4.7.1. Нийслэлд дагуул шинэ хот байгуулж хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.
- 4.7.2. Майдар сити, Аэйро сити, Шинэ зуун мод зэрэг дагуул хотын төслийг бүхий л талаар дэмжиж ажиллана.
- 4.7.3. Хотоос алслагдсан дүүргүүдийн хотын төлөвлөлтийг эхлүүлнэ.
- 4.7.4. Улаанбаатар хотын тойрог замуудыг байгуулж, дагуул, хаяа хотуудыг холбон хөгжүүлнэ.
- 4.7.5. Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг бий болгож, дулаан цахилгааны шугам сүлжээг өргөтгөж найдвартай нөхцөлийг хангана.

4.8. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

- 4.8.1. Аймгийн төвүүдийн гэр хорооллын өсөлтийг хязгаарлах, бууруулах бодлого боловсруулан дэд бүтцийг хөгжүүлж нэгдсэн цахилгаан дулааны станц байгуулан бага оврын уурын зуухны хэрэглээг халж агаарын бохирдлыг бууруулах шат дараатай арга хэмжээг авна.
- 4.8.2. Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг хангах, төсөв бүрдүүлэх, захиран зарцуулах эрхийг нэмэгдүүлнэ.
- 4.8.3. Орон нутгийн баялгаас улсын төсөвт оруулж байгаа орлогоос тодорхой хувийг төсөвт нь шууд хуваарилдаг тогтолцоотой болгоно.
- 4.8.4. Бүс нутагт газар зүй, хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, бизнесийн орчин нөхцөлтэй уялдсан татвар, татаасны бодлого хэрэгжүүлнэ.

12


00000012

- 4.8.5. Орон нутгийн төвлөрүүлсэн татварын тодорхой хувийг тухайн нутагт нь зориулах, зарцуулалтыг ил тод болгох, бүсчлэн хөгжүүлэх бодлого, санаачилгыг дэмжинэ.
- 4.8.6. Бэлчээрийг хамгаалж, малын тоо толгойг зохистой хэмжээнд барих, малын удмын санг сайжруулах, чанарт анхаарах талаар төрөөс дэмжлэг үзүүлэх тусгай хөтөлбөр боловсруулж ажиллана.
- 4.8.7. Малын махыг зах зээлд худалдан борлуулах хяналтыг сайжруулан, вакцинжуулалтад онцгой анхаарч малын эрүүлжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 4.8.8. Орон нутаг, байгаль цаг уурын онцлогоос шалтгаалж гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуй эрхлэх, ферм байгуулах төсөл хөтөлбөрийг дэмжинэ.
- 4.8.9. Инженерийн байгууламж бүхий цэвэр бохир усны сүлжээнд холбогдсон, соёл үйлчилгээний төвүүдийг төлөвлөсөн сумын төвийг хөгжүүлэх бодлого санаачилгыг дэмжин 330 сумдыг үе шаттайгаар шинэчилнэ.
- 4.8.10. Орон нутаг тэр дундаа алслагдсан сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, хүний нөөцөд хөрөнгө оруулалт хийж чанартай эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭКОЛОГИ

- 5.1. Ногоон хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчинд ээлтэй бизнесийг дэмжих, хөгжүүлэх цогц бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 5.2. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, агаарын болон хөрсний бохирдол, усны нөөцийн хомсдол, хөрсний элэгдэл, цөлжилт, бэлчээрийн доройтол зэрэг асуудалд онцгой анхаарч экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаална.
- 5.3. Хүн амын төвлөрөл ихтэй бүс нутагт агаар, хөрсний бохирдлыг бууруулах асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх.
- 5.4. Томоохон хот сууринд үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, орчны бохирдлыг бууруулна.
- 5.5. Түүхий нүүрс, занарыг дахин боловсруулж утаагүй хатуу түлш, шингэн түлш, эрчим хүч үйлдвэрлэх аливаа санаачилгыг дэмжинэ.


ЗУРГАА. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, сэргээхийг нэн тэргүүний зорилт болгоно. Үг хэлэх эрх чөлөө бол бусад бүх эрх, эрх чөлөөний тулгуур үнэт зүйл юм. Эрх баригч өрсөлдөгчийнхөө амыг таглах эрх мэдэлтэй болчихвол өөр эрх байхгүй.

- 6.1. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэсэн, тууштай гадаад, дотоод бодлого хэрэгжүүлж ажиллана.
- 6.2. Гадаад харилцаанд эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлж гуравдагч хөршийн харилцааг нэмэгдүүлэх экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

- 6.3. Экспортыг дэмжих гуравдагч хөршийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн хүрээнд төмөр зам, авто замын бүтээн байгуулалтыг өрнүүлж экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлнэ.
- 6.4. Гадаадын хөрөнгө оруулалтын хувийн байгууллагад татан төвлөрүүлэх, чөлөөт бүсийг байгуулах, хөрөнгө оруулагчид ээлтэй хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 6.5. Монгол Улсаас баримтлах гадаад бодлогын хүрээнд төрийн байгууллагуудыг нэгдсэн зохион байгуулалт, удирдлагаар хангаж гадаад харилцааны асуудлыг шийдвэрлэх.
- 6.6. Хилийн чанад дахь иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг өргөжүүлж нийгмийн хамгааллын асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх.
- 6.7. Түүх, соёлын салбарт гадаад харилцааг өргөжүүлж салбарын экспортыг дэмжиж эрх зүйн орчныг сайжруулна.
- 6.8. Төрийн албаны бүтээмжийг нэмэгдүүлж орон тоог цөөлөх бодлого хэрэгжүүлэн сонгон шалгаруулалтын нөхцлийг сайжруулна.
- 6.9. Төрийн албан хаагчдын ажил үүргээ хэвийн, үр дүнтэй, шударгаар, шуурхай явуулах орчин нөхцөл, цалин хангамж, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.10. Албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх, хууль бус хөрөнгийг хураах, хөөн хэлэлцэх хугацаагүй болгох зэрэг замаар сонгогдсон болон томилогдсон төрийн албан тушаалтанд авч хэрэгжүүлэх хариуцлагыг чангатгана.
- 6.11. Хэзээ ч улс төрийн өрсөлдөгчдийн эсрэг хуулиар зэвсэглэхгүй, албан тушаалтныг хуулиас дээгүүр тавихгүй.
- 6.12. Цөөнх болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэний эрхийг хангахад онцгой анхаарна.
- 6.13. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үзүүлэх ялын хатуу бодлогыг барих болно.
- 6.14. Цагдаа, прокурор, шүүх зэрэг байгууллагуудын санхүүжэлтийг нэмэгдүүлэхийн оронд өөрчилнө. Гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд ажилладаг тогтолцоог бүрдүүлнэ, шаардлагагүй баривчлах биш, хурцадмал байдлыг намжаах, зуучлах үр чадварт сургаж хамтран ажиллах болно.
- 6.15. Хууль, хүчний байгууллагын олон нийттэй харилцах харилцаа нь сөргөлдөөн байхаа болино. Тэд иргэдийг дарамтлах бус хүнд гэмт хэрэгт анхаарлаа хандуулах болно.

oooOOOooo

14


00000014